



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 08 сарын 24 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээ тогтоох тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.4 дугаар заалт, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.6 дугаар заалт, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2021 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. 2021-2022 оны хичээлийн жилд Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бакалаврын сургалтад суралцагчдын сургалтын нэг кредитийн төлбөрийг нэмэгдүүлэхгүйгээр хавсралтаар тогтоон мөрдсүгэй.

2. Магистрантурын сургалтын нэг кредитийн төлбөрийг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн төлбөрийг 1.4 коэффициентоор үржүүлж тогтоосугай.

3. Докторантурын сургалтын нэг кредитийн төлбөрийг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн төлбөрийг 1.9 коэффициентоор үржүүлж тогтоосугай.

4. Бизнесийн ахисан түвшний сургууль, Инженерийн ахисан түвшний сургууль, Нээлттэй боловсролын төвийн сургалтын нэг кредитийн төлбөрийг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн дундаж үнэлгээг магистрантурт 1.4, докторантурт 1.9 коэффициентоор үржүүлж тогтоосугай.

5. Цагийн сургалтаар элсэн суралцаж буй оюутны сургалтын нэг кредитийн төлбөрийг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн төлбөрийг 1.2 коэффициентоор үржүүлж тогтоосугай.

6. Шинжлэх ухаан, технологийн их сургуульд хэрэгжүүлж буй гадаадын их, дээд сургуулиудтай хамтарсан хөтөлбөрийн хүрээнд гадаад хэл дээр заагдаж буй хичээлийн нэг кредитийн төлбөрийг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн төлбөрийг 2.0 коэффициентоор үржүүлж тогтоосугай.

7. Шинжлэх ухаан, технологийн их сургуульд суралцах гадаад оюутны сургалтын нэг кредитийн төлбөрийг тооцохдоо энэхүү тогтоолын 1-5 дахь заалтуудыг баримталсугай.

8. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Ерөнхий боловсролын Ахлах сургууль, бүрэлдэхүүн ШУТИС-Коосен технологийн коллежийн 2021-2022 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрийг 3.000.000 (гурван сая) төгрөгөөр, Дархан-Уул аймаг дахь Ерөнхий боловсролын Ахлах сургуулийн сургалтын төлбөрийг 1.200.000 (нэг сая хоёр зуун мянган) төгрөгөөр тогтоосугай.

ДАРГА  Т.ГАНБАЯР

UNIVERSITY OF
MONGOLIAN
SCIENCE AND
TECHNOLOGY
ТА1161 9087087

E:\file\2021 он\Тушаал\A4.docx

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2021 оны 08
дугаар сарын 24-ний өдрийн 04 дугаар
тогтоолын хавсралт



**ШУТИС-ИЙН 2021-2022 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД МӨРДӨХ
НЭГ КРЕДИТИЙН ҮНЭЛГЭЭ**

д/д	Сургууль	Хөтөлбөрийн ангилал	Нэг кредитийн үнэлгээ /төгрөгөөр/			
			2021/2022 оны хич. жилд элссэн	2019/2020, 2020/21 оны хич. жилүүдэд элссэн	2018/2019 оны хич.жилд элссэн	2018 оноос өмнө элссэн
1	БАРИЛГА, АРХИТЕКТУРЫН СУРГУУЛЬ	Инженер, технологи	90,800	90,800	82,390	80,300
2	ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН СУРГУУЛЬ				82,390	80,300
3	МЕХАНИК ТЭЭВРИЙН СУРГУУЛЬ				82,390	80,300
4	МЭДЭЭЛЭЛ ХОЛБОО ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ				86,790	84,590
5	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ				82,390	80,300
6	ЭРЧИМ ХҮЧНИЙ СУРГУУЛЬ				84,370	82,170
7	БИЗНЕСИЙН УДИРДЛАГА, ХҮМҮҮНЛЭГИЙН СУРГУУЛЬ	Нийгмийн ухаан	88,800	88,800	86,790	84,590
8	ГАДААД ХЭЛНИЙ СУРГУУЛЬ	Хэрэглээний шинжлэх ухаан	79,300	79,300	72,160	70,400
9	ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ				74,360	72,490
10	ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ				75,790	73,920
ШУТИС-ийн дундаж			83,130			